

РЕДАКТОРЫН ҮГ

Энэхүү эмхэтгэлд ОХУ-ын ШУА-ийн Хэл шинжлэлийн хүрээлэнгийн Оросын ард түмнүүдийн хэлийг судлах салбараас зохион байгуулж буй “Монгол хэлнүүд: түүх ба орчин үе” (Санкт-Петербург, 2013 оны 10 сарын 21–23) олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд оролцогчдын илтгэлийг хэвлэн хүргэж байна. Эмхэтгэлд багтсан судалгааны бүтээлүүд нь монгол хэлнүүдийн судлалын тулгамдсан асуудлыг дэвшүүлэн тавьсан төдийгүй тэдгээрийг шийдвэрлэх орчин үеийн арга замыг тусгажээ. Монгол хэл шинжлэлийн онолын болоод арга зүйн цаашдын хөгжилд хувь нэмэр болохуйц суурь судалгааны шинжтэй бүтээлүүд болон хээрийн шинжилгээ, архивын эх сурвалж, хэвлэл мэдээлэлд суурилсан тодорхой судалгаануудын үр дүнг оновчтой уялдуулсан нь сайшаалтай.

Эмхэтгэлд орсон бүтээлүүдийн зохиогчид нь үндсэндээ Оросын болон дэлхийн монгол хэл судлалын төвүүдийг төлөөлж байгаа бөгөөд ОХУ-ын Санкт-Петербург хотоос А.А. Бурыкин, А.М. Певнов, П.О. Рыкин, Т.Д. Скрынникова, Н.С. Яхонтова, Москва хотоос С.А. Крылов, В.Э. Раднаев, Улаан-үүд хотоос Н.Б. Бадмацыренова, Г.А. Дырхеева, М.М. Пильчинова, Е.В. Сундуева, Г.Н. Чимитдоржиева, Элистэй хотоос Д.Б. Гедеева, Д.Н. Музраева, В.И. Рассадин, С.М. Трофимова, Монгол улсаас Л. Болд, М. Энхбат, Унгар улсын Сегед хотоос Б. Кемпф, БНХАУ-аас Ланжу хотын Б. Отгон, Хөх хотын Чжэн Юэ (Цагаансар), Юй Жун, Ю. Ямада, Словак улсын Братислав хотоос Ж. Тан, Финландын Хельсинки хотоос Ю. Янхунен, Швед улсын Стокгольм хотоос Б. Бросиг, Япон улсын Мацуяма хотоос Ё. Кобаяси, К. Хигути, Токио хотоос Х. Умэтани нарыг дурьдаж болно.

Танилцуулан буй бүтээлүүдийг дараах сэдэвчилсэн ангилалд хуваан авч үзэж болохоор байна. Үүнд:

- 1) Монгол бичиг үсгийн түүх болон XVI–XIX-р зууны монгол бичгийн дурсгалуудад хийсэн хэл шинжлэлийн судалгаа (Д.Б. Гедеева, Д.Н. Музраева, Б. Отгон, Чжэн Юэ (Цагаансар), К. Хигути нарын илтгэлүүд);
- 2) Түрэг-монгол хэлнүүдийн харилцан нөлөөлөл, монгол хэлэн дэх түрэг хэлний үгсийн сангийн нөлөө (Л. Болд, В.И. Рассадин, Т.Д. Скрынникова нарын илтгэлүүд);

- 3) Монгол болон манж-тунгуус хэлнүүдийн түүхэн харилцаа, харилцан-нөлоолөл, монгол-манж хэлнүүдийн үгсийн сангийн дурсгалуудын судалгаа (А.М. Певнов, Г.Н. Чимитдоржиева, М. Энхбат, Ю. Янхунен, Н.С. Яхонтова нарын илтгэлүүд);
- 4) Монгол хэлнүүдийн түүхэн авиан зүй болон өвөг монгол хэлний өмнөх үеийн хэлбэрийг сэргээн судлах асуудал (П.О. Рыкин, Ю. Ямада нарын илтгэлүүд);
- 5) Монгол хэлнүүдийн хэлний зүйн судалгааны асуудлууд (Н.Б. Бадмацыренова, Б. Бросиг, Х. Умэтани нарын илтгэлүүд);
- 6) Монгол хэлнүүдийн үгсийн сангийн болон гарал зүйн судалгаа (Б. Кемпф, В.Э. Раднаев, С.М. Трофимова, В.И. Рассадин нарын илтгэлүүд);
- 7) Корпус хэл шинжлэл болон монгол хэл шинжлэлд түүнийг хэрэглэх асуудал (С.А. Крылов, Юй Жун нарын илтгэлүүд);
- 8) Нийгэм хэл шинжлэл болон монгол хэлнүүдийн социологи, хэлний бодлогын асуудлууд (Г.А. Дырхеева, Ё. Кобаяси, М.М. Пильчинова нарын илтгэлүүд) зэрэг болно.

Үүний сацуу зарим судлаачид бүтээлдээ авианы утга (Е.В. Сундуева), алтай хэлнүүд дэх үгсийн сангийн нөлөө, зээлдмэл үгсийг илрүүлэх арга зүй (А.А. Бурыкин), Хятаны их бичгийг тайлж унших аргачлал (Ж. Тан) зэрэг тодорхой асуудлыг дэвшүүлсэн байна.

Өгүүлэн буй “Монгол хэлнүүд: түүх ба орчин үе” олон улсын бага хурал нь монгол хэлнүүдийг судлах шинэ судалгааны төвийн бааз суурь дээр түшиглэн зохион байгуулагдаж байгаа юм. Энэ шинэ төв бол Санкт-Петербург хотноо байдаг уламжлалт хоёр монгол судлалын төв болох ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлүүдийн хүрээлэнгийн Төв болон Өмнөд Азийн судлалын салбарын Төв Ази судлалын тасаг болон Санкт-Петербургийн Улсын их сургуулийн Дорно дахины салбарын Монгол, төвд судлалын тэнхмээс тусдаа байгууллага болно. Энэ шинэ төв нь ОХУ-ын ШУА-ийн Хэл шинжлэлийн хүрээлэнгийн Оросын ард түмнүүдийн хэлийг судлах салбар дээр 1960–70 онд В.М. Надеяев, Л.А. Карабаева, С.Л. Чареков нарын үүсгэн байгуулсан монгол судлалын уламжлалыг үргэлжлүүлэх зорил-

гоор 2000-аад оны эхээр хэлбэржин тогтсон юм. Өнөөдөр энэхүү төвийн үйл ажиллагааг тус салбарын ажилтнууд болох хэл бичгийн ухааны доктор Сергей Леонидович Чариков, түүхийн ухааны дэд доктор Павел Олегович Рыкин, түүхийн ухааны дэд доктор Влада Вячеславовна Баранова нар эрхлэн явуулж байна. Санкт-Петербург хотын монгол судлалын уламжлалт хоёр төвтэй харьцуулбал, энэ төвийн онцлог нь монгол хэлнүүдийн цуваа болон хам цагийн судалгааны өргөн хүрээг хамарсан хэл шинжлэлийн гүнзгийрүүлсэн судлагаагаар тодорхойлогдоно. ОХУ-ын ШУА-ийн Хэл шинжлэлийн хүрээлэнгийн монгол судлаачид шинжлэх ухааны хэд хэдэн чиглэлээр судалгаа шинжилгээ хийж байна. Үүнд:

С.Л. Чариков – Зэрэгцүүлсэн үг зүй (бүтээвэр зүй), буриад, эвенк хэлнүүдийн үгсийн сан, хэлний гарал зүй;

П.О. Рыкин – Монгол хэлнүүдийн түүхэн авиан зүй, дундад үеийн монгол хэл, монгол бичиг үсгийн түүх, түрэг-монгол хэлнүүдийн харилцаа холбоо;

В.В. Баранова – Халимаг хэлний зүй, Халимаг дахь хэлний өнгөрсөн ба одоогийн нохцол байдал зэрэг судалгааг онцлон дурьдах нь зүйтэй.

Мөн тус хүрээлэнгийн монгол судлалын төвийн эрдэмтэн судлаачид «Монгол хэлнүүдийн түүхэн хөгжлийн асуудлууд» (Санкт-Петербург, 2007 оны 10 сарын 24–26) олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулсан бөгөөд хурлын үр дүн болгож, илтгэлийн эмхэтгэлийг “Проблемы исторического развития монгольских языков: Материалы международной научной конференции” (Санкт-Петербург, 24–26 октября 2007 г.) / Эрхлэн нийтлүүлсэн П.О. Рыкин. СПб.: Нестор-История, 2007, нэрээр хэвлүүлсэн юм.

Түүнчлэн эдгээр монгол судлаачид судалгааны үр дүнгээ хэвлэн нийтлэж, шинжлэх ухааны эргэлтэд оруулахад анхааран ажиллаж байна. Тэд судалгааны үр дүнгээсээ эрдэм шинжилгээний хурлууд, олон улсын томоохон форум дээр тавьж хэлэлцүүлсний дотор Монгол судлалын IX, X-р их хурал (Улаанбаатар, Монгол улс, 2006, 2011), “Хүн төрөлхтөн, хөгжил ба соёлын олон талт байдал” сэдэвт Хүн судлал, угсаатны зүйн олон улсын холбооны 16-р их хурал (БНХАУ, Кунминь, 2009),

“Мөхөж буй хэлнүүд болон түүх” сэдэвт Мөхөж буй хэлнүүдийг хамгаалах сангийн 13-р олон улсын бага хурал (Тажикстан, Хорог, 2009) зэрэг хуралд оролцсон байна. Монгол болон Алтай судлалын төвийн ажилтнуудын 2003-2013 онуудад хэвлүүлсэн гол бүтээлүүдийг дор дурьдав. Үүнд:

С.Л. Чареков:

- К происхождению языка, Санкт-Петербург, 2011, 85 т.
- Специфика агглютинативной суффиксации эвенкийского языка, *Актуальные проблемы монголоведения* 4, Улан-Удэ, 2011, 23–34.
- Лексическая полисемия в эвенкийском и бурятском языках, Санкт-Петербург, 2010, Б.1: Имена существительные и прилагательные, 132 т.
- Семантическая структура локативных падежей эвенкийского языка, *Вестник ЛГУ им. А.С. Пушкина* 5(1), 2010, 138–149.
- Семантическая структура словообразования в русском и алтайских языках, Хянан засварласан хоёр дахь хэвлэл, Санкт-Петербург, 2009, 116 т.
- Семантическая структура словообразования в русском и алтайских языках, Санкт-Петербург, 2004, 105 т.

П.О. Рыкин:

- К вопросу о принципах китайской транскрипции монгольской лексики в китайско-монгольском словаре *Дада юй/Бэйлу иуй* (конец XVI–начало XVII в.), *Олон улсын монголч эрдэмтний Х их хурлын илтгэлүүд. Proceedings of the 10th International Congress of Mongolists*, Улаанбаатар, 2012, vol. 2: *Монгол хэл, соёлын тулгамдсан асуудлууд. Mongolian Language and Culture and their Urgent Problems*, 339–348.
- Китайская транскрипция монгольских велярных и увулярных согласных в словаре *Дада юй/Бэйлу иуй* (конец XVI–начало XVII в.), «Живём дружно, “молодые” разного возраста»: *Сб. ст. в память востоковеда-тюрколога А.Н. Самойловича*, М., 2012, 87–120.
- On the principles of Chinese transcription of Mongolian sounds in the Sino-Mongolian glossary *Dada yu/Beilu yiyu* (late 16th–early 17th century), *Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae* 65:3, 2012, 323–334.

– *Тырские стелы XV века: Перевод, комментарии, исследование китайских, монгольского и чжурчжэньского текстов* (В.Ц. Головачев, А.Л. Ивлиев, А.М. Певнов нарын хамт), Санкт-Петербург, 2011, 320 т. + 117 зураг.

– The System of Kinship and Affinity Terms in Middle Mongolian, *Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae* 64:1, 2011, 25–47.

– Towards an etymology of Middle Mongolian *Bodončar* ~ *Bodančar*, *Mongolo-Tibetica Pragensia '10: Ethnolinguistics, Sociolinguistics, Religion and Culture* 3:1, 2010, 105–122.

– Семантический анализ терминов родства и свойства в среднемонгольском языке, *Вопросы филологии. Серия Урало-алтайские исследования* 1(1), 2009, 80–91.

– Методы и принципы семантического описания социальной лексики в среднемонгольском языке (на материале терминов родства), *IX Международный конгресс монголоведов (Улан-Батор, 8–12 августа 2006 г.): Доклады российских ученых*, М., 2006, 330–339.

В.В. Баранова:

– Enseignement du kalmouk et situation linguistique (fin 1950–2000), *L'édification linguistique en URSS: thèmes et mythes*, [= Cahiers de l'Institut de linguistique et des sciences du langage; № 35.], Lausanne, 2013, 75–99.

– Каждый калмык должен знать родной язык? (Языковая лояльность сообщества в диахронии), *Nomen est omen: Сб. ст. к 60-летию Н.Б. Вахтина (от непослушных учеников)*, Санкт-Петербург, 2010, 15–23.

– Пути грамматикализации глагола *gi-* ‘говорить’ в калмыцком языке, *Труды межинститутской научной конференции «Востоковедные чтения 2008» (Москва, 8–10 октября 2008 г.)*, [= Бюллетень Общества востоковедов; 17.], М., 2010, 96–114.

– Deportation and Language Identity in Kalmykia, *Endangered Languages and History: Proceedings of the Thirteenth FEL Conference, 24–26 September 2009, Khorog, Tajikistan*, S.l., 2009, 67–71.

– Языковая ситуация в Калмыкии: Социолингвистический очерк, *Исследования по грамматике калмыцкого языка*, [= Acta Linguistica Petropolitana. Труды Института лингвистических исследований РАН; 5/2], Санкт-Петербург, 2009, 22–43.

– Сложные глаголы в калмыцком языке, *Исследования по грамматике калмыцкого языка*, [= Acta Linguistica Petropolitana. Труды Института лингвистических исследований РАН; 5/2], Санкт-Петербург, 2009, 255–309.

Эмхэггэлийн хянан тохиолдуулагч-редакторын зүгээс тус эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулах Комиссын гишүүд болох түүхийн ухааны дэд доктор В.В. Баранова, хэл бичгийн ухааны дэд доктор А.А. Сюрюн, докторант С.А. Оскольская нарт шинжлэх ухааны энэхүү арга хэмжээг зохион байгуулахад үнэлж баршгүй хувь нэмрээ оруулсанд, мөн өмнөх үгийг орчуулсан Монгол улсын Нүүдлийн соёл, иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Д. Пүрэвжав, түүнчлэн уг хурлыг зохион байгуулах, эмхэтгэлийг хэвлэх ажлыг эхнээс аван дуустал нь тууштай дэмжиж, гүнээ тусалсан ОШУА-ийн Хэл шинжлэлийн хүрээлэнгийн захирал, академич Н.Н. Казанский болон захирлын эрдэм шинжилгээ эрхэлсэн орлогч, Оросын ард түмнүүдийн хэлний салбарын эрхлэгч, ОШУА-ийн сурвалжлагч гишүүн Е.В. Головки нарт гүн талархал дэвшүүлж, сайн сайхныг хүсэн ерөөе.

Орос хэлнээс орчуулсан Д. Пүрэвжав